

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БНА-2024/01-НА-СТА

Цахим хуудас: www.audit.mn	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 70442424 Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 99061861 Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Аудитор: Б.Наранцэцэг Утас: 88093788	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Цахим хаяг: Doljmaab@audit.gov.mn Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хаяг: bunchisurenn@audit.gov.mn Цахим хаяг: narantsetseb@audit.gov.mn
Баянхонгор хот 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Тайланг хянасан		АГУУЛГА	
Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
	Ахлах аудитор М.Алтантуяа	Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3
Тайланг бэлтгэсэн		Аудитын зорилт.....	3
Ахлах аудитор	Б.Должмаа	Аудитын хамарсан хүрээ.....	3
Аудитор	Б.Нарангэрэл Н.Бунчинсүрэн Б.Наранцэцэг	Аудитын арга зүй	3
		Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт.....	4
		Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн	4
		Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам 4	
		Товчилсон үгийн тайлбар.....	5
		ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	5
		БҮЛЭГ 1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ЗАРИМ АЖ АХУЙН НЭГЖҮҮД ГЭРЭЭНИЙ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС ХАНДИВЫН ОРЛОГО ТАСАРСАН БАЙНА	6
		Татварын орлого.....	8
		Татварын бус орлого.....	10
		БҮЛЭГ 2 АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 22.2.4 ДЭХ ХЭСЭГ, 24.5, 24.6 ДАХЬ ЗААЛТЫН ДАГУУ БАТАЛСАН БАЙНА	12
		БҮЛЭГ 3 АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ЗҮЙ ЗОХИСТОЙ, ҮР АШИГТАЙ БАЙДЛААР ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 54.5-Т ЗААСАН БҮРЭЛДЭХҮҮНЭЭР ГАРГАСАН ХЭДИЙ Ч ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРСЭН ҮР ДҮНГ НЭГТГЭН ТООЦОЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА	20
		БҮЛЭГ 4. ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА	23
		6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл.....	23
		8 дугаар зүйл. Дүрэмт хувцас.....	24
		12 дугаар зүйл. Бусад хангамж.....	24
		13 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ....	24
		15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ.....	25
		БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТӨЛБӨРИЙН АКТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛААГҮЙ БАЙНА	25
		БҮЛЭГ 6. БАЯНХОНГОР АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	28
		АУДИТЫН ДҮГНЭЛТ	30
		АУДИТЫН ЗӨВЛӨМЖ	31
2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр			
Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.open.audit.mn			
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.			
ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс			

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5¹-д заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” 2023 оны А75 дугаар тушаал, газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/01 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд

- Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх,
- Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 22.2.4 дэх хэсэг, 24.5, 24.6 дахь заалтын дагуу батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх.
- Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн орлого, зарлагыг зүй зохистой, үр ашигтай байдлаар Төсвийн тухай хуулийн 54.5-т заасан бүрэлдэхүүнээр гарган, хэрэгжүүлж хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтод түвшинд нийцсэн эсэх.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэн ажилласан эсэх
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан эсэх
- Баянхонгор аймгийн 2023 оны төсвийн төсөлд өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын газрын аудитад хамрагдах татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2023 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан

¹8.9.4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

**Аудитад
ашигласан
шалгуур үзүүлэлт**

Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-4:2020 “Төрийн аудит. Санхүүгийн аудит”, 6817-6 :2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Тусгай сангийн тухай хууль
- ТБОНӨТХ
- ТБОНӨБАҮХАТХ
- Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”
- Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- Баянхонгор аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж

**Аудитыг
гүйцэтгэсэн
хугацаа, аудитын
багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, ахлах аудитор менежер М.Алтантуяа үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа ахалж, аудитор Б.Нарангэрэл, Н.Бүнчинсүрэн, Б.Наранцэцэг нар 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

**Аудитын
тайлангийн бүтэц,
түүнд тусгагдсан
мэдээлэл,
хэлэлцүүлсэн
журам**

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, аудитын тайланг ҮАГ-ын Санхүү, нийцлийн аудитын газар, Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, Баянхонгор аймгийн Татварын газарт хүргүүлэв.

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨ	Орон нутгийн өмч
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨХЭ	Орон нутгийн өмчит хуулийн этгээд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТБОНӨХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦХТАО	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн албаны тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон, УИХ-аас Төсвийн тухай хуульд 5 удаа нэмэлт өөрчлөлт орсон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг шинэчлэн найруулсан, Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон, 444 дүгээр тогтоолоор төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн тогтоосон байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 3,169.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 6 санал, суурь зарлагыг 1,133.3 сая төгрөгөөр бууруулах 9 санал, төсвийн үр ашгийг 5,753.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 9 санал, нийт 10,056.0 сая төгрөгийн 24 саналыг хүргүүлснийг зарим саналыг хүлээн аваагүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргаас 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 13,651.4 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлсэн, саналыг 3,336.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 16,988.3 сая төгрөгөөр хянасан бөгөөд Төсвийн тухай хуулиар Сангийн яамны хянасан дүнг 7,972.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 24,960.3 сая төгрөгөөр баталжээ. Тайлант онд анх баталсан дүнд аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолоор тодотгол хийж, нийт орлогыг 4,281.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 29,241.6 сая төгрөгөөр баталжээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар тогтоолоор нийт 67,388.7 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 15/42 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор анхны батлагдсан төсвийг 10,527.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 77,916.3 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Тайланд онд аймгийн татварын орлогоор 20,190.1 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 23,644.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 3,454.5 сая төгрөгөөр давуулан биелсэн байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны 77,916.3 сая төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 69,931.0 сая төгрөгийг зарцуулж, зардлын гүйцэтгэл 7,985.3 сая төгрөг байгаа нь төлөвлөсөн хандивын орлого бүрэн төвлөрөөгүй, 9 сумын Хоршоо хөгжүүлэх сан тайлант онд төлөвлөсөн хөнгөлөлттэй зээлийг олгоогүй, төлөвлөсөн зардлыг хэмнэж ажилласан зэрэгтэй холбоотой байна.

Баянхонгор аймгийн СТСХ нь аймгийн Засаг даргын харьяаны байгууллага, сумдын Засаг даргын тайлан дахь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу жилийн эцсийн тайланд тайлагнасан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг нэгтгэж дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ЗАРИМ АЖ АХУЙН НЭГЖҮҮД ГЭРЭЭНИЙ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС ХАНДИВЫН ОРЛОГО ТАСАРСАН БАЙНА.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 19,843.9 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 12,601.5 сая, нийт тусламж санхүүжилтийн орлогыг 32,445.4 сая төгрөгөөр баталсан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс Сангийн яаманд татварын орлогыг 12,151.4 сая, хүү, торгуулийн орлогыг 1,500.0 сая, нийт 13,651.4 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яам татварын орлогыг 14,556.8 сая, татварын бус орлогыг 2,431.6 сая төгрөг, нийт 16,988.4 сая төгрөгийг оруулахаар хянаж баталсан байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны хянасан дүнг 7,971.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 24,960.3 сая төгрөгөөр баталсныг тодотголоор 4,281.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 29,241.6 сая төгрөгөөр баталжээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 19,595.8 сая төгрөг, татварын бус орлогыг 2,889.3 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 19,843.9 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэг 12,601.5 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр 2,353.8 сая, хандивын орлогоор 2,887.1 сая, хөрөнгийн орлогоор 260.0 сая, өмнөх оны төсвийн үлдэгдэл 6,957.3 сая, нийт эх үүсвэр 67,388.8 сая төгрөгөөр, 2023 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 67,388.8 сая төгрөгөөр баталжээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 15/42 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор анхны батлагдсан төсвийг 10,527.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 77,916.3 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор Баянхонгор аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 3,351.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол АМНАТ-ын орлогын гүйцэтгэлээс шалтгаалж Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэгийг 2,803.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

ОНХНС-аас аймагт 7,072.9 сая, сумдад 8,332.4 сая, нийт 15,405.3 сая төгрөгийг олгохоос тайлант онд 15,192.4 сая төгрөгийг олгож, 212.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон ба энэ нь жилийн эцэст АМНАТ-ын орлогын гүйцэтгэл тасарсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Аймгийн 2023 оны төсвийн суурь зарлагын эх үүсвэр (сая.төг)

Үзүүлэлт	Баянхонгор аймаг		
	Өмнөх оны гүйцэтгэл	2023 он	
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв
А	1	2	3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	58,993.2	67,388.8	77,916.3
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	20,134.0	25,372.3	27,407.3
1. Татварын орлого	16,617.2	19,595.8	20,190.1
2. Татварын бус орлого	3,516.8	5,776.4	7,217.2
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	40.0	260.0	460.0
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	17,678.0	32,445.4	38,601.1
Г. ӨМНӨХ ОНЫ ХЭМНЭГДСЭН ЗАРДАЛ, ТЭНЦЛИЙН АШГААС	0.0	0.0	0.0
Д. ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ	7,030.8	6,957.3	9,038.5
Е. СУМДЫН ТУСГАЙ САНГУУД	14,110.4	2,353.8	2,409.4
Ё. ГАДААДЫН ТӨСЛИЙН ЗЭЭЛЭЭС	0.0	0.0	0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,993.2	67,388.8	77,916.3
А. УРСГАЛ ЗАРЛАГА	42,342.8	40,877.4	47,187.6
1. Бараа, үйлчилгээний зардал	41,183.5	38,515.5	44,723.5
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,642.0	1,763.8
3. Татаас ба урсгал шилжүүлэг	32.0	719.7	700.3
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,650.4	23,144.4	27,306.1
УРСГАЛ ТЭНЦЭЛ	-22,208.8	-15,505.1	-19,780.3
НИЙТ ТЭНЦЭЛ	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд

1.2 Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Татварын болон татварын бус орлогыг өмнөх оны гүйцэтгэл, Сангийн яамнаас хянасан дүн, мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаанд үндэслэн төлөвлөсөн бөгөөд урсгал орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 2,812.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар аймаг, сумдын ИТХ-аар 77,916.3 сая төгрөгийн нийт эх үүсвэрийг баталж, гүйцэтгэлээр 69,606.3 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн ажилласан байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар татварын орлого 23,644.6 сая, улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 23,195.8 сая, ОНХНС-аас авсан санхүүжилт 15,192.4 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 2,831.9 сая, хүү торгуулийн орлого 1,884.4, хандивын орлого 2,180.0 сая, хөрөнгийн орлого 677.2 сая, нийт 69,606.3 сая төгрөгийг эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Сангийн яамны Э-тайлан дахь орлогын гүйцэтгэлийн тайлангийн орлого 67,842.7 сая, гүйцэтгэл 67,426.2 сая төгрөг байгаа нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын гүйцэтгэл 69,606.2 сая буюу 2,180.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хандивын орлогын гүйцэтгэлийг гадаадын эх үүсвэр дансаар төлөвлөгөөг оруулсантай холбоотой байна.

Татварын орлого

Тайланд онд татварын орлогыг 20,190.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 23,644.6 сая төгрөгийг оруулан төлөвлөгөөг 3,454.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт (сая.төг)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлогын албан татвар	20,190.1	23,644.6	-3,454.5	117.1
Хувь хүний орлогын албан татвар	12,488.79	13,755.39	-1,266.60	110.1
Хөрөнгийн албан татвар	2,889.1	2,701.7	187.4	93.5
Бусад татвар, төлбөр, хураамж	4,812.2	7,187.5	-2,375.3	149.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аймгийн Татварын газрын аймгийн төсвийн болон сумдын төсвийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аудитын явцад тулган шалгахад аймгийн Татварын газрын орлого 20,294.3 сая төгрөгөөр тайлагнаж, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 104.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Татварын газар хувь хүний буцаалтын 795.5 сая, аймгийн Замын сангийн зам ашигласны төлбөрийн 300.0 сая, газрын дуудлага худалдааны орлогын 389.9 сая төгрөгийг төлөвлөгөөнд оруулдаггүйтэй холбоотой байна.

Тайлант онд төлөвлөсөн 20,190.1 сая төгрөгийн татварын орлогыг 23,644.6 сая биелүүлснээс ан амьтны нөөц ашигласны төлбөр 210.8 хувь, улсын тэмдэгтийн хураамж 205.7 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 195.1 хувь, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого 117.1 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 114.1 хувь, орон нутгийн зам ашигласны хураамжийн орлогыг 111.7 хувиар тус тус давуулан биелүүлжээ.

Хүснэгт 3. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

Код	Үзүүлэлт	2023 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20,190.1	23,644.6	-3,454.5	117.1
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	10,203.4	11,950.8	-1,747.4	117.1
110002	Үйл ажиллагааны орлого	800.0	719.1	80.9	89.9
110003	Хөрөнгийн орлого	1,203.7	1,263.6	-59.9	105.0
110004	Хөрөнгө борлуулсны орлого	410.0	388.4	21.6	94.7
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-793.3	-795.6	2.3	100.3
110301	ААН-ын орлогын албан татвар	665.0	229.1	435.9	34.5
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	637.4	666.2	-28.8	104.5
113002	Бууны албан татвар	75.6	64.0	11.6	84.6
113003	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	610.0	678.6	-68.6	111.2
113004	Малд ногдуулах албан татвар	1,566.1	1,292.9	273.2	82.6
118001	Улсын тэмдэгтийн хураамж	305.0	627.5	-322.5	205.7
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	102.8	200.5	-97.7	195.1
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	828.9	945.8	-117.0	114.1
118011	Бусад татвар	300.0	335.0	-35.0	111.7
118101	Газрын төлбөр	746.9	775.3	-28.4	103.8
118102	Дуудлага худалдаа	390.0	279.9	110.1	71.8
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,681.4	3,544.1	-1,862.7	210.8
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	457.2	468.1	-10.9	102.4
118301	Бусад татвар	0.0	11.3	-11.3	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төлөвлөгөөнөөс давж биелсэн татварын орлогод дүн шинжилгээ хийхэд дараах хүчин зүйл голлох нөлөөг үзүүлсэн байна. Үүнд:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 10,203.3 сая төгрөгөөр төлөвлөж, 1,747.4 сая төгрөгөөр давж биелэн 11,950.7 сая төгрөгийн татвар төсөвт төвлөрсөн нь 2023 онд Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор зарим төрийн албан хаагчдын цалингийн шатлалыг өөрчилж, нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 1,681.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,544.1 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлж 1,862.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь 2023 онд зарим сум ан агнуур агнуулах гэрээгээр шонхор шувууг барих гэрээг олон тоогоор байгуулсан холбоотой байна.

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тайлант онд 102.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 97.7 сая төгрөгөөр давж биелэн 200.5 сая төгрөг орсон нь Хүрээмарал, Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж хийж байгаа аж ахуйн нэгжүүд татварыг өндөр төлсөнтэй холбоотой байна.

- Хог хаягдлын хураамжийн орлого өмнөх жилүүдтэй харьцуулахад төлөвлөсөн хураамжийг давуулан биелүүлсэн нь хог хаягдлын хураамжийг цахилгааны төлбөр дээр нэмж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

- Хөрөнгө борлуулсны орлого 410.0 сая төгрөгөөр төлөвлөж, 388.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 637.4 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 666.2 сая төгрөгийг оруулсан зэрэг нь тайлант онд иргэдийн худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгөөс холбогдох хуулийн хүрээнд ногдуулалт хийсэнтэй холбоотой байна.

Тайлант онд орлогын төлөвлөгөө биелээгүй татварыг нэр төрлөөр нь авч үзвэл дараахь орлогууд тасарсан байна. Үүнд:

- Бууны албан татварыг тайлант онд 75.6 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 64.0 сая төгрөгийг төвлөрүүлэн, татварын орлогын төлөвлөгөө 11.6 сая төгрөгөөр тасарсан нь уг татварыг төлөвлөхдөө аймгийн Цагдаагийн газарт бүртгэлтэй буугаар төлөхөөр тооцсон нь нөлөөлсөн байна.

- Малын тоо толгойн албан татварын хууль баталснаар орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж зэрэг асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг олгосон, аймгийн Татварын газраас үүсгэсэн малчин өрх мал бүхий 15,524 татвар төлөгчөөс 1,503.2 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварын ногдуулалтыг нэхэмжлэх үүсгэсэн байхад тайлант онд 1,566.1 сая төгрөгөөр төлөвлөж, 1,299.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

№	Сумдын нэр	Татвар төлөгчийн тоо	Нэхэмжлэхийн дүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувь
1	Баацагаан	968	98.4	103.6	80.4	77.6
2	Баянбулаг	412	30.0	28.0	33.0	117.8
3	Баянговь	739	56.6	50.0	51.3	102.5
4	Баянлиг	878	96.6	97.0	97.2	100.2
5	Баян-Овоо	752	170.1	228.4	165.9	72.6
6	Баян-Өндөр	618	72.4	60.0	61.0	101.6
7	Баянхонгор	976	93.0	37.8	46.3	122.3
8	Баянцагаан	832	41.4	65.4	43.7	66.9

9	Богд	710	81.7	75.5	76.2	100.9
10	Бөмбөгөр	920	34.0	83.7	31.3	37.3
11	Бууцагаан	909	101.6	102.0	64.8	63.5
12	Галуут	1,059	55.0	69.3	65.5	94.6
13	Гурванбулаг	586	19.7	30.0	30.0	99.9
14	Жаргалант	773	67.7	62.9	58.8	93.4
15	Жинст	540	95.1	95.0	94.1	99.0
16	Заг	544	42.6	25.0	35.2	140.7
17	Өлзийт	974	135.0	132.4	94.9	71.7
18	Хүрээмарал	482	45.8	60.1	34.1	56.7
19	Шинэжинст	701	80.1	80.0	72.0	90.0
20	Эрдэнэцогт	1,151	86.4	80.0	64.2	80.2
	ДҮН	15,524	1,503.2	1,566.1	1,299.6	83.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын ирүүлсэн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө Бууцагаан, Баян-Овоо, Бөмбөгөр сумдад татварын байцаагч тогтвортой бус, удирдлага зохион байгуулалтын хангалтгүй ажилласнаас шалтгаалан тасарсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар тогтоолоор хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 800.0 сая төгрөг баталсныг Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/19 дүгээр тушаалд баталсан 793.2 сая төгрөгөөр олгохоор тооцож, аймгийн ИТХ-ын хуралдааны 15/42 дугаар тогтоолоор тус дүнгээр баталжээ.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 255 дугаар албан бичгээр нэг иргэний татварын буцаан олголтод 2.7 сая төгрөгийг олгох хүсэлтийг аймгийн СТСХ-т хүргүүлснийг аймгийн ИТХ-аар хэлэлцээгүй олгосон байгаа тул цаашид ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллах зөвлөмжийг аймгийн Татварын газарт хүргүүлэв.

Татварын бус орлого

Татварын бус орлогоор 2023 онд 9,051.5 сая төгрөгийн орлогыг оруулахаар баталснаас гүйцэтгэлээр 5,393.4 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөө 3,658.1 сая төгрөгөөр тасарчээ.

Хүснэгт 5.Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая:төг)

Код	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийтлэг бус татварын орлого	4,611.50	4,716.20	-104.70	102.3
120002	Хүүгийн орлого	750.7	46.0	704.7	6.1
120003	Торгуулийн орлого	1,781.80	1,838.30	-56.50	103.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,822.80	2,482.00	-659.20	136.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	256.1	349.9	-93.8	136.6
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	460	677.2	-217.2	147.2
122002	Хандив тусламж /гадаад/	3,980.10	2,180.00	1,800.10	54.8
	ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ДҮН	9,051.50	7,573.40	1,478.10	83.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүүгийн орлогоор 750.7 сая төгрөгийг төлөвлөсөн нь “Баянхонгор Чандмань” ХК, “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-ийн урт хугацаат OL-1847MON-08, OL-1847MON-04 төслийн зээлийн хүүгийн орлогыг төлөхтэй холбоотой бөгөөд 2023 онд дээрх аж ахуйн нэгжүүдээс 46.0 сая төгрөгийн зээл, хүүгийн орлого төвлөрүүлснийг гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Төрийн аудитын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Цагдаагийн газруудаас тогтоосон торгуулийн орлогоор тайлант онд 1,781.8 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 1,838.3 сая төгрөгийг оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор анх 260.0 сая төгрөгөөр төлөвлөснийг тээврийн хэрэгслийн дуудлага худалдаа, 3 нэрийн хөрөнгийг дуудлага худалдаагаар сонгон шалгаруулалт явуулахаар төлөвлөж, тус орлогыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гүйцэтгэлээр 677.2 сая төгрөгийг төсөвт оруулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2023 онд үндсэн үйл ажиллагааны орлогоор нийт 1,822.8 сая төгрөг оруулахаар төлөвлөснийг 659.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж, гүйцэтгэлээр 2,482.0 сая төгрөгийг оруулсан байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогоор 1,298.9 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 1,169.0 сая төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөө 129.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 6. Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Галуут	55.0	71.9	130.7	11	Заг	33.0	38.1	115.3
2	Баян-Овоо	68.6	76.7	111.8	12	Баацагаан	113.2	60.4	53.4
3	Эрдэнэцогт	15.0	20.6	137.1	13	Бөмбөгөр	25.0	38.1	152.4
4	Бууцагаан	40.1	58.5	146.0	14	Өлзийт	70.0	99.9	142.7
5	Жинст	102.7	58.5	56.9	15	Хүрээмарал	52.9	43.3	81.9
6	Богд	51.1	75.8	148.2	16	Баянбулаг	98.4	76.9	78.1
7	Баянлиг	16.2	23.0	141.5	17	Шинэжинст	63.4	115.1	181.4
8	Баянговь	69.1	41.6	60.2	18	Баянцагаан	60.7	68.8	113.3
9	Гурванбулаг	37.0	28.8	77.9	19	Баян-Өндөр	48.9	47.5	97.2
10	Жаргалант	110.3	64.0	58.0	20	Баянхонгор	168.3	61.7	36.7
						ДҮН	1,298.9	1,169.0	90.0

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд орлогын төлөвлөгөөг Баянхонгор сум 36.7 хувь, Баацагаан сум 53.4 хувь, Жинст сум 56.9 хувь, Жаргалант сум 58.0 хувь, Баянговь сум 60.2 хувьтай биелүүлсэн нь хамгийн бага үзүүлэлттэй байгаа, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 7 сумын 307.5 сая төгрөгийн 9 зөрчилд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас холбогдох шийдвэрийг гарган хүргүүлсэн байгаа зэрэгт аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд 2023 онд нийт 523.8 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,259.1 сая төгрөгийг оруулсан ба 2024 онд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэх гүйцэтгэлийн аудитаар ОНХС-ийн орлого, зардлыг тодруулан авч үзэх болно.

Аймгийн СТХС-ээс ОНХС-ийн орлого, зардлын бүртгэлийг ямар дансаар дамжуулах чиглэлийг сумдад өгч ажиллаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Өлзийт сумын ОНХС-ийн орлогыг 39.2 сая төгрөгөөр төлөвлөж үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн байхад орлогын гүйцэтгэл 119.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан зөрчил илэрсэнд төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулсан;

- Аймаг, сумдын ОНХС-ийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байхад Хүрээмарал сум 34.6 сая төгрөгийн ОНХС-ийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор төлөвлөж, тайлагнасан байгаа тул ОНХС-ийн орлого, зардлын бүртгэлийн талаар мөрдөж буй НБББББ-т тодорхой тусган ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Туслах үйл ажиллагааны орлого

Төсөвт байгууллагуудын туслах үйл ажиллагааны орлогоор 221.5 сая, ОНХС-ийн туслах үйл ажиллагааны орлогоор 34.7 сая, нийт 256.2 сая төгрөгийн орлого оруулахаар баталснаас гүйцэтгэлээр төсөвт байгууллагууд 215.8 сая, ОНХС 134 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний орлого

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээний загварын 2.1.3 дахь хэсэг, холбогдох хуулиудыг үндэслэн аймгийн Засаг дарга “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 9 аж ахуйн нэгжтэй “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээ байгуулсан байна.

Эдгээр гэрээгээр аймгийн ОНХС-д анх 2,568.1 сая төгрөгийг оруулахаар баталж, тодотгосон төсвөөр 730.0 сая төгрөгийг нэмэгдүүлж, 3,298.1 сая төгрөгөөр баталсан нь “Эрдэнэ монгол” ХХК-ийн 2024 онд гэрээгээр төлөх 730.0 сая төгрөгийг урьдчилж авсантай холбоотой байна. Гүйцэтгэлээр уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс 2,180.0 сая төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд болон аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний дагуу техник хяналтын зардалд 4 аж ахуйн нэгж гэрээнд заасан 4.0 сая төгрөгийн төлөөгүй зөрчил илэрсэнд орон нутгийн төсөвт нөхөн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

- Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд болон аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-нд заасан ажлын байр бий болгох, гэрээний хэрэгжилтийг дүгнэж аймгийн ИТХ-д хүргэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа тул аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн.

БҮЛЭГ 2 АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 22.2.42 ДЭХ ХЭСЭГ, 24.53, 24.64 ДАХЬ ЗААЛТЫН ДАГУУ БАТАЛСАН БАЙНА.

² 22.2.4.хөтөлбөрөөр

³ 24.5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

⁴ 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 49 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 123 байгууллагын санхүүгийн тайлан, 110 боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардал, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө, замын сан, техник хяналт, барьцаа, аймгийн ОНХС-ийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор 2023 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 67,388.7 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 15/42 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор анхны батлагдсан төсвийг 10,527.6 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлэн нийт зардлыг 77,916.3 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Хүснэгт 7. Аймаг, сумын ИТХ-аар баталсан 2023 оны нийт төсөв (сая.төг)

Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,388.7	77,916.3	10,527.6
УРСГАЛ ЗАРДАЛ	44,149.2	50,390.2	6,241.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,882.5	48,146.1	6,263.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,513.8	15,614.4	3,100.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,565.4	1,984.3	418.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,573.6	14,497.3	-76.3
Хангамж, бараа материалын зардал	2,170.5	2,459.7	289.3
Нормативт зардал	76.8	86.7	9.9
Эд хогшил, урсгал засварын зардал	804.1	1,594.8	790.6
Томилолт, зочны зардал	288.8	382.5	93.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,207.8	2,490.7	282.9
Бараа үйлчилгээний бусад зардал	7,681.7	9,035.6	1,353.9
ТАТААС	48.0	0.0	-48.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	48.0		-48.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,218.7	2,244.1	25.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,547.0	1,543.9	-3.1
Бусад урсгал шилжүүлэг	671.7	700.3	28.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,610.6	26,775.4	4,164.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	628.9	750.7	121.8
Дамжуулан зээлдэхийн төлбөр	628.9	750.7	121.8

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын 2022, 2023 оны тогтоол

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2023 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр төрийн албан хаагчийн цалинг 2023 оны 07 сарын 01-ээс нэмэгдүүлснээс 3,100.6 сая, НДШ 418.9 сая, үйл ажиллагааны бусад зардлыг 2,744.1 сая, урсгал шилжүүлгийг 25.4 сая, хөрөнгийн зардлыг 4,164.8 сая, дамжуулан зээлүүлэх төлбөрийг 121.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 77,916.3 сая төгрөгийн төсөв батлагдаж 69,931.0 сая төгрөг зарцуулснаас урсгал зардалд 46,804.4 сая, хөрөнгийн зардалд 22,463.5 сая, хугацаат дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрт 663.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 8. Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Б	3	4	5=3-4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,916.3	69,931.0	7,985.3
УРСГАЛ ЗАРДАЛ	50,390.2	46,804.4	3,585.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,146.1	44,803.4	3,342.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,614.4	15,267.0	347.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,984.3	1,874.4	110.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,497.3	14,052.3	445.0
Хангамж, бараа материалын зардал	2,459.7	2,362.5	97.2
Нормативт зардал	86.7	85.2	1.5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,594.8	1,506.9	87.9
Томилолт, зочны зардал	382.5	361.5	21.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,490.7	2,203.9	286.8
Бараа үйлчилгээний бусад зардал	9,035.6	7,089.8	1,945.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,244.1	2,001.0	243.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,543.9	1,439.2	104.7
Бусад урсгал шилжүүлэг	700.3	561.8	138.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,775.4	22,463.5	4,311.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	750.7	663.1	87.6
Дамжуулан зээлдэхийн төлбөр	750.7	663.1	87.6
АЖИЛЛАГСДЫН ТОО	851	845	6
Удирдах ажилтан	219	219	0
Гүйцэтгэх ажилтан	461	463	-2
Үйлчлэх ажилтан	110	112	-2
Гэрээт ажилтан	61	51	10

Эх сурвалж: Аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад 77,916.3 сая батлагдаж гүйцэтгэлээр 69,931.0 сая төгрөг зарцуулж 7,985.3 сая төгрөгийг дутуу зарцуулсан ба үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 347.4 сая, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 110.0 сая, байр ашиглалтад холбоотой тогтмол зардлыг 445.0 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,945.8 сая, хөрөнгийн зардлыг 4,311.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлох нөлөө үзүүлж байна.

Бараа үйлчилгээний бусад зардал 1,945.8 сая төгрөг дутуу зарцуулсан байгаа нь хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйгээс 1,461.8 сая төгрөг хэмнэсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Аудитаар зарим зардлын үр дүнг судалгаагаар нэгтгэхэд дараах байдалтай байна. Үүнд:

✓ Аймгийн ЗДТГ орон нутгийн хэвлэл мэдээллийн 6 байгууллагатай 28.0 сая, 3 сумын ЗДТГ “Малчин” телевиз болон орон нутгийн “Номгон” телевизтэй 8.5 сая, аймгийн ОНӨГ орон нутгийн “Өлзийтийн хийморь өөдөө” ХХК-тай 1.0 сая, нийт 37.5 сая төгрөгийн гэрээг байгуулж, зардлыг олгосон байна. Хамтран ажиллах гэрээнд аймгийн ИТХ болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, төр засгийн бодлого шийдвэр, цаг үеийн онцлог үйл явдал, бүтээн байгуулалтын ажлын явц зэргийг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулахаар заажээ.

✓ “Тэрбум” мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд уул уурхайн “Оюу толгой” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс монгол” ХХК-ууд 50,000.0 мянган ширхэг, Хил хамгаалах Ерөнхий газар 5.0 мянган ширхэг, аймгийн Цагдаагийн газар, “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ, Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг болон 4,5,8 дугаар баг 22.6 мянган ширхэг

буюу нийт 50,027.6 мянган ширхэг мод тарих амлалтыг өгч, 2023 онд 32.7 мянган мод тарьсан байна.

✓ “Тэрбум” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Баянхонгор аймгийн 20 сум 2023 онд 1,009.4 сая төгрөгийн 159.3 мянган ширхэг мод тарихаар төлөвлөж гүйцэтгэлээр 728.5 сая төгрөг зарцуулж 306.1 мянган ширхэг мод тарьсан байна. Төлөвлөсөн тооноос илүү мод тарьсан нь зарим сум төлөвлөөгүй мод тарьсан, хандиваар мод ирсэнтэй холбоотой байна.

✓ “Өвсний үндэс” хөтөлбөрийн 685.3 сая төгрөгийн санхүүжилтээр 2023 он Бууцагаан сумын хуучин цэцэрлэгийн барилгын их засварыг хийж гүйцэтгэн, ашиглалтад хүлээн авсан байна.

✓ Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэг байрны хүрэлцээгүй хангалтгүй, 2 дугаар цэцэрлэгийн шинэ барилга баригдаж дуусаагүй, Политехникийн коллежийн дотуур байрны ашиглалтын хугацаа дууссан зэрэг шалтгааны улмаас түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж, тайланд онд орон нутгийн төсвөөс 151.7 сая төгрөгийг түрээсийн зардалд олгохоор баталсныг бүрэн санхүүжүүлсэн байна. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын байр Монгол ардын намын байртай залгаа баригдсан байдаг ба тус намын байрыг өмнө нь хууль хяналтын байгууллагаар намын байр гэж тогтоож, салгаж үйл ажиллагаа явуулах боломжгүйгээс 225м2 талбай бүхий байрыг аймгийн ЗДТГ түрээслэн 32.4 сая төгрөгийг түрээсийн зардалд төлсөн байна.

✓ Аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдож, шүүхийн шийдвэрээр ажилд эргүүлж томилсон ажилтнуудад 2022 оноос өмнөх онуудад 14 албан хаагчдад 70.4 сая төгрөгийг төсвөөс олгосон ба буруутай албан тушаалтнаар 2023 онд 7 хүний 53.5 сая төгрөг төлөгдсөнөөс 6 хүний 50.2 сая төгрөгийг аймгийн Засаг дарга асан Г.Батжаргал Төрийн албаны зөвлөлийн дансанд төвлөрүүлсэн, 1 хүний 3.3 сая төгрөгийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн бөгөөд 2023 онд 1 албан хаагчийн 11.5 сая төгрөгийг төсвөөс олгож 2023 оны эцэст 8 албан хаагчийн 28.4 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг буцаан төлүүлээгүй байна.

✓ Баянхонгор аймгийн Засаг дарга “Ухаалаг засаглал” НҮББ, “Хог биш баялаг” НҮББ-тай гэрээ байгуулж, төсвөөс 22.6 сая төгрөгийг олгохоор баталсныг бүрэн олгожээ. “Ухаалаг засаглал” НҮББ 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг хөгжүүлэх, ашиглалт, үйлчилгээний гэрээ”-г байгуулж, 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч, харин “Хог биш баялаг” НҮББ нь “Цэвэр хот ОНӨААТҮГ”-т тоног төхөөрөмж шууд нийлүүлэх гэрээг байгуулж, 12.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 12/54 дүгээр “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор 6 үндсэн зорилтын хүрээнд 151 арга хэмжээг улс, аймгийн орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр бусад эх үүсвэрээс хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан.

Аймгийн ИТХ-ын XII хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн дугаар хуралдааны 12/55 дугаар “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 1,210.0 сая төгрөгийн 29 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 7/03 дугаар тогтоолоор 9 төсөл арга хэмжээнд 567.2 сая төгрөгийг нэмэгдүүлэн 1,777.2 сая төгрөгөөр 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын хэмнэлтээс аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/614 дүгээр захирамжаар 10.8 сая төгрөгийг АДЗТГ-ын гадаад томилолтын зардалд зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Баянхонгор аймагт 2023 онд хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын жагсаалтад "Жаргалтай амьдрал төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" арга хэмжээнд 200.0 сая төгрөг батлагдсан байна. Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/680 дугаар "Төсөвт зохицуулалт хийх тухай" захирамжийг үндэслэн тус төвд 14.0 сая төгрөгийг нэмж батлан, 214.0 сая төгрөгийг олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 45 дугаар зүйлийн 45.2 дахь "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:" 45.2.2 дахь "Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн тул алдаа зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргэв.

Орон нутгийн хөгжлийн сан:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд улсын төсвөөс Баянхонгор аймагт олгох орлогын шилжүүлгийг 12,601.5 сая төгрөг баталсан ба Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 15,405.3 сая төгрөг, үүнээс аймгийн ОНХС-д 7,072.9 сая, сумдын ОНХС-д 8,332.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоор хуульчилсан байна.

Аймгийн ИТХ-ын XII дугаар хуралдааны 2022 оын 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/55 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 5,156.5 сая, аймгийн ОНХС-д бусад эх үүсвэрээс 2,568.1 сая, зураг төсвийн орлого 250.0 сая нийт 7,974.6 сая төгрөг, сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 7,445.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлын эх үүсвэрийн 25,252.2 сая төгрөгөөр баталж, ОНХС-аас 15,192.4 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар болон бусад эх үүсвэрээс 3,281.6 сая, хандив тусламжийн орлого 2,180.0 сая, зураг төсвийн орлого 251.3 сая, өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 2,932.8 сая нийт 23,838.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Хандив тусламжийн орлогоор нийт 3,980.1 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн нь уул уурхайн компаниудаас Шинэжинст сум 300.0 сая төгрөг, аймгийн ОНХС-д 1,880.0 сая нийт 2,180.0 сая төгрөг орсон байна.

Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлыг 25,252.2 сая төгрөгөөр баталж, 20,940.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 7,072.9 сая, зураг төсвийн орлогыг 250.0 сая, хандивын орлого 3,298.1 сая, өмнөх оны мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 23.6 сая нийт 10,644.6 сая төгрөгөөр нийт 91 төсөл арга хэмжээг 10,644.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж гүйцэтгэлээр 9,224.7 сая төгрөгийн зардал гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолоор сумын Соёлын төвд тоног төхөөрөмж бэлтгэх 4 төсөл арга хэмжээнд тус бүр 20.0 сая, Баянхонгор сумын хогийн цэг булшлахад 3 төсөл арга хэмжээнд тус бүр 20.0 сая, "Тэрбум мод", өвлийн хүлэмж, ногоон байгууламжийн усалгаатай холбоотой 4 арга хэмжээнд тус бүр 20.0

сая төгрөгийг баталсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд аймгийн ИТХ-д цаашид төсөл арга хэмжээг хэт жижиглэн батлахгүй байхыг толилуулав.

- Аймгийн ОНХС-д уул уурхайн компаниудаас орох хандив төлөвлөсөн хэмжээнд ороогүй 1,418.1 сая төгрөгийн эх үүсвэр дутагдсан, мөн өмнөх онуудад олгосон Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-аас хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн авлага 672.4 сая төгрөг байгаа зэргээс шалтгаалж 7 төсөл арга хэмжээнд 521.5 сая төгрөгийн өглөг үүссэн байна. Иймд ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, зураг төсвийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, дутуу олгогдсон 521.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг 2024 онд ОНХС-аар хэрэгжих ТАХ-ын жагсаалтад оруулан аймгийн ИТХ-аар батлуулж өглөгийг барагдуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар шалгах болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумдын ОНХС-д нийт 2,214.1 сая төгрөгийн 21 алдаа зөрчил илэрснээс 397.5 сая төгрөгийн 12 алдааг зарлуулж, 71.0 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 1,602.4 сая төгрөгийн зөрчил арилгах 20 албан шаардлага, 143,2 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

Их засвар

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 17 төсөл арга хэмжээний 1,523.2 сая төгрөгийн их засварын ажил батлагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн орон нутгийн төсвөөр 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 17 төсөл арга хэмжээний 1,523.2 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 1,522.6 сая төгрөг зарцуулсан байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,514.4 сая төгрөгөөр тайлагнасан тул төсвийн гүйцэтгэлийн тайланд 8.1 сая төгрөгийн залруулгыг хийсэн.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Орон нутгийн төсвөөр 2023 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтад “Дөвөнтийн заалны их засвар хийх” арга хэмжээнд 86.3 сая төгрөг батлагдсан байхад 126.3 сая төгрөг буюу 40.0 сая төгрөгийг илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн тул алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувиллын төв болгох төсөл арга хэмжээнд 251.3 сая төгрөг баталсан байхад 251.9 сая төгрөг буюу 0.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

Техник хяналт, барьцаа хөрөнгө оруулалтын данс

Төрийн сан дахь 100030051350 тоот Барьцаа хөрөнгө оруулалт дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,115.7 сая төгрөг, тайлант хугацаанд 1,257.7 сая төгрөгийн орлого төвлөрч, 2,831.2 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцсийн үлдэгдэл 2,542.2 сая төгрөг байна.

Барьцаа хөрөнгийн дансанд УТХО, аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 22 төсөл арга хэмжээний 1,257.7 сая төгрөг төвлөрснөөс чанарын баталгаа 849.8 сая, дуусаагүй 9 ажлын 407.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Барьцаа хөрөнгө оруулалтын дансны орлого, зарлагын гүйлгээ (сая.төг)

№	Хөрөнгө оруулалтын ажлын нэр	Байршуулсан дүн	Үүнээс: Чанарын баталгаа	Дуусаагүй ажлын санхүүжилт
1	УТХО-аар хэрэгжсэн ТАХ	854.3	737.2	117.1
2	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ	403.4	112.6	290.8
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		1,257.7	849.8	407.9

Эх сурвалж: Аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Барьцаа хөрөнгийн данснаас тайлант онд 2,831.2 сая төгрөгийн зарлага гарсан ба үүнээс 18 төсөл арга хэмжээний 2,307.6 сая төгрөгийн барьцааг чөлөөлж буцаан шилжүүлсэн бөгөөд 3 төсөл арга хэмжээний 523.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төрийн сан дахь 100030051370 тоот Бх.Техник хяналт зардлын дансанд оны эхэнд 379.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд 632.1 сая төгрөг төвлөрч, 318.3 сая төгрөгийн зарцуулалт гарч оны эцэст 693.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Замын сан

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 610.0 сая, орон нутгийн авто зам ашигласны төлбөр 300.0 сая, торгуулийн орлого 600.0 сая, урьд оны үлдэгдлээс 37.0 сая төгрөгийг оруулахаар санхүүгийн эх үүсвэрийг нийт 1,547.0 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн 15/42 тогтоолоор өмнөх оны үлдэгдэл 3.1 сая төгрөгийг хасаж тодотгон өмнөх оноос шилжих 1 төсөл, арга хэмжээнд 105.0 сая, 2023 онд шинээр хэрэгжүүлэх 22 төсөл, арга хэмжээнд 1,543.9 сая төгрөг зарцуулахаар баталсан.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 33.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвараар 678.6 сая, авто зам ашиглалтын хураамж 335.0 сая, торгуулийн орлого 430.7 сая нийт 1,444.3 сая төгрөгийн санхүүжилт авч 19 төсөл арга хэмжээнд 1,439.1 сая төгрөгийн зардал гаргаж 39.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шинэжинст, Баянлиг, Баянговь сумдын зам засварын 3 арга хэмжээ хэрэгжээгүй нь зураг төсөв хийгдээгүй, Эрдэнэмандал хайрхны зам засварын ажил нь Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээтэй давхацсан зэрэг шалтгаалсан байна.

Тайлант онд 1,137.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 6 төсөл арга хэмжээний 909.2 сая төгрөгийн гэрээ байгуулж 197.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд 2 удаа нээлттэй тендер зарлан шаардлага хангасан оролцогч ирээгүй тул шууд гэрээ байгуулсан байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/55 дугаар тогтоолоор байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 6 төсөл арга хэмжээнд 150.5 сая төгрөг батлагдсан бөгөөд тодотголоор 8 арга хэмжээ болгон өөрчилж 145.2 сая төгрөгийг зарцуулж 5.3 сая төгрөгийг орон нутгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Тухайн онд хэрэгжих 8 төсөл арга хэмжээнээс 250.0 сая төгрөгийн өртөгтэй тайлант онд санхүүжих 160.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 240.7 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна.

Хоршоо хөгжүүлэх сан

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл оны эхэнд 1,146.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан, тайлан онд зээлийн эргэн төлүүлэхээр 1,298.9 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 1,169.0 сая төгрөгийг төвлөрүүлж 930.8 сая төгрөгийн зарлага гаргаж оны эцэст 1384.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 10. Сумын хоршоо хөгжүүлэх мөнгөн хөрөнгийн судалгаа (сая.төг)

Д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1	Баацагаан	6.8	66.5	11	Бууцагаан	47.9	25.3
2	Баянбулаг	29.9	63.1	12	Галуут	39.9	28.7
3	Баянговь	6.7	46.2	13	Гурванбулаг	102.7	131.4
4	Баянлиг	210.6	113.2	14	Жаргалант	109.1	67.3
5	Баян-Овоо	13.9	90.5	15	Жинст	0.1	58.3
6	Баян-Өндөр	43.7	21.3	16	Заг	27.2	65.2
7	Баянхонгор	101.4	161.7	17	Өлзийт	40.4	124.2
8	Баянцагаан	59.8	64.4	18	Хүрээмарал	116.4	4.0
9	Богд	26.2	100.5	19	Шинэжинст	38.2	54.0
10	Бөмбөгөр	20.1	57.2	20	Эрдэнэцогт	104.9	41.3
Нийт дүн						1,146.1	1,384.3

Эх сурвалж: Аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 2,409.4 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 921.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

Хүснэгт 11. Сумын хоршоо хөгжүүлэх зарлагын судалгаа (сая.төг)

Д/д	Сумын нэр	зарлага		Д/д	Сумын нэр	зарлага	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баацагаан	113.2		11	Бууцагаан	88.0	81.2
2	Баянбулаг	128.3	43.6	12	Галуут	94.9	83.1
3	Баянговь	75.8		13	Гурванбулаг	139.7	
4	Баянлиг	226.8	120.4	14	Жаргалант	219.5	105.9
5	Баян-Овоо	82.5		15	Жинст	102.8	
6	Баян-Өндөр	91.2	70.0	16	Заг	60.0	
7	Баянхонгор	268.8		17	Өлзийт	110.0	16.1
8	Баянцагаан	110.7	64.2	18	Хүрээмарал	169.3	155.8
9	Богд	76.6		19	Шинэжинст	100.5	96.7
10	Бөмбөгөр	40.0		20	Эрдэнэцогт	111.0	84.2
Дүн						2,409.4	921.1

Эх сурвалж: Аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд 2,409.4 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 921.1 сая төгрөгийн зээл олгосон, 9 сум хөнгөлөлттэй зээлийг олгоогүй байна.

Иймд Хоршоо хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийг ИТХ-ын баталсан дүнгээр тухайн жилд олгож орон нутагт шинээр үйлдвэрлэл бий болгох, жижиг дунд үйлдвэрлэлийг өргөжүүлж ирээдийн амьдралд бодит орлогыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 307.5 сая төгрөгийн зөрчил илэрч 3.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 273.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 213.9 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Бөмбөгөр сумын Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан нэг зээлдэгчийн 3.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл хугацаа хэтэрсэн тул төлбөрийн акт тогтоосон;
- Хөнгөлөлттэй зээл авсан Баян-Өндөр сум 1 зээлдэгчийн 1.0 сая, Баянцагаан сум 12 зээлдэгчийн 16.7 сая, Баацагаан сум 15 зээлдэгчийн 54.5 сая, Баянбулаг сум 4 зээлдэгчийн 18.5 сая төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаа хэтэрсэн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;
- Баян-Өндөр сумын хоршоо хөгжүүлэх сангаас 2022-2023 онуудад олгосон 8 зээлдэгчийн 160.0 сая төгрөгийн зээлийн гэрээний хавсралт зээлийн эргэн төлөлтийн хуваарийг жилд 1 удаа төлөхөөр байгуулсан тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн;
- Баянлиг сумын хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр "Хулдаасан хэвлэлийн машин"-ийг худалдан авахаар 35.0 сая төгрөгийн зээл авсан иргэн тус хөрөнгийг худалдан аваагүй зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.
- Баацагаан сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 2013-2017 онд зээл авсан 5 зээлдэгчийн нийт 15.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг шүүхийн шатанд шилжүүлж эвлэрлийн гэрээ байгуулж боловч зээлийг төлөөгүй зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн;
- Богд сумын Хоршоо хөгжүүлэх сангаас өмнөх онуудад зээл авсан 10 зээлдэгчийн зээл, зээлийн хүүг 7.3 сая төгрөгөөр илүү, 56 зээлдэгчийн зээл, зээлийн хүүг 7.5 сая төгрөгөөр дутуу төлснөөр тайлагнаж, дэлгэрэнгүй тайланд үлдэгдэлгүй бүртгэсэн зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 3 АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ЗҮЙ ЗОХИСТОЙ, ҮР АШИГТАЙ БАЙДЛААР ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 54.55-Т ЗААСАН БҮРЭЛДЭХҮҮНЭЭР ГАРГАСАН ХЭДИЙ Ч ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРСЭН ҮР ДҮНГ НЭГТГЭН ТООЦОЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн XII дугаар хуралдааны 12/55 дугаар “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” тогтоолын нэгдүгээр хавсралтаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг баталсан байна.

Дээрх тогтоолоор 16 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 28,455.5 сая төгрөгийг баталж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумдын ИТХ-аар тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Тайлант онд нийт баталсан төсвийг 7,985.3 мянган төгрөгөөр хэмнэж, 69,931.0 мянган төгрөгийг зарцуулсан ба аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлтээр нь дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт (сая.төг)

Хөтөлбөрийн		Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
Нэр	Код			
Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	70105	Хурлын хуралдааныг улиралд 1-с доошгүй, удаа хуралдуулж шийдвэр гаргана.	4,477.4	4,230.7
		Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөг баталж биелэлтийг хангуулж, Гэмт хэргийн зөрчил буурна.		
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	70106	Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудыг бодлого, удирдлагаар хангаж аймаг, сумдын ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлнэ.	24,946.6	23,611.0
Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	70503	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 44 ажил арга хэмжээ, Их засварын 9 ажил арга хэмжээг хэрэгжүүлэх болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг 100% хэрэгжүүлнэ.	26,775.4	22,463.5
Замын сан	71101	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 22 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1,543.9	1,439.2

⁵ Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна

Нийгмийн халамж	71902	Баянхонгор аймгийн 768 иргэнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлнэ.	160.2	66.9
Нийгмийн халамж	71902	Баянхонгор аймгийн 86 иргэнд амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж үзүүлнэ.		37.2
Мал аж ахуйг хөгжүүлэх	70801	20 суманд үзүүлэх мал эмнэлгийн үйлчилгээг санхүүжүүлнэ.	508.8	508.8
Мал аж ахуйг хөгжүүлэх	70801	20 суманд малыг вакцинд бүрэн хамруулна.	219.3	219.3
Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	71411	Байгаль орчны багц хууль болон дүрэм, журам, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлнэ.	1,018.2	970.4
Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	71413	Байгаль орчин нөхөн сэргээх 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	150.5	145.2
Ойжуулалт	71403	Мод үржүүлгийн талбай, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж жилд 500 мянган ширхэг тарьц суулгацыг нийлүүлэхээр зорин ажиллаж, үүнээс тус онд 200 мянган ширхэг мөчрийн тайрдас бэлдэж, талбайдаа тариалалт хийнэ.	156.5	157.7
Хот байгуулалт тохижилт	71502	Баянхонгор аймгийн нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийж, халтиргаа гулгааг арилгаж, ногоон байгууламжийн арчилгаа, үйлчилгээг хийн нэмэгдүүлж иргэдийн цэвэр тавтай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.	1,255.0	1,248.4
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	70426	Улс, орон нутгийн төсвийн худалдан авах ажиллагааг 100% цахимаар зохион байгуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулна.	344.3	340.2
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	70426	Төрийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бодлогоор удирдлагаар хангах, Орон нутгийн өмчийн дуудлага худалдаа зохион байгуулна.		
Ахмад настны хөгжил хамгаалал	72208	10 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлж, ахмадын хорооны үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	194.0	194.0
Эмнэлгийн тусламж үйлчилгээ	71602	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	1,008.1	933.9
Сургуулийн өмнөх боловсрол	71801	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	2,083.2	2,007.6
Ерөнхий боловсрол	71802	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	6,822.6	6,746.1
Биеийн тамир спорт	71701	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	1,430.1	1,391.6
Соёл урлаг	71702	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	1,856.5	1,670.4
Мэргэжлийн боловсрол	71804	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	556.5	534.0
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	72101	Хоршоо хөгжүүлэх санд төлөвлөсөн хөнгөлөлттэй зээлийг олгоно.	2,409.4	1,014.9
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	72101	Зээлийн эргэн төлөлтийг бүрэн төвлөрүүлсэн байна.		
ДҮН			77,916.3	69,931.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгддэг байгууллагууд нь аймгийн Засаг даргатай 2023 оны үр дүнгийн гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг тайлагнан дүгнүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-аас Төрийн аудитын газарт аймгийн Засаг даргын сайд нартай байгуулсан 2023 оны гэрээний хэрэгжилтийг ирүүлсэн ба 90-100 хувиар үнэлж холбогдох сайдуудад хүргүүлжээ.

Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 88.8 хувьтай, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 89.7 хувьтай, Баянхонгор аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 84.6 хувьтай тайлагнасан байна.

Баянхонгор аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг Баянхонгор аймгийн СТСХ-ээс дараах байдлаар тайлагнасан байна.

- ✓ Аймгийн ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаан 5 удаа хуралдаж, 58 асуудлыг хэлэлцэн 55 тогтоолыг батлан хэрэгжүүлсэн байна.
- ✓ Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдаанаар баталсан 2023 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 70 заалт бүхий арга хэмжээг 238.9 сая төгрөг зарцуулан хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 66 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг 90.3 хувьтай тайлагнасан бөгөөд гарсан гэмт хэргийн тоог өнгөрсөн онтой харьцуулахад 44 нэгжээр буюу 10 хувиар буурсан байна.
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 41 ажил арга хэмжээг 4,570.5 сая, их засварын 9 ажил арга хэмжээг 1,015.5 сая төгрөгөөр бүрэн санхүүжүүлж, аймгийн хэмжээнд 75 хувьтай хэрэгжүүлсэн байна.
- ✓ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 479 иргэнд 66.8 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.
- ✓ Аймгийн хэмжээнд 31 иргэнд 37.2 сая төгрөгийг амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг олгож ажилласан.
- ✓ 20 сумын хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 51 аж ахуй нэгжид 508.8 сая төгрөгийн санхүүжилт олгож малын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн хэрэгжүүлсэн.
- ✓ Орон нутаг хариуцах вакцины үнэд 219.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 853614 тоо толгой малыг вакцинд хамруулснаар халдварт өвчний гаралт 53 хувиар буурсан байна.
- ✓ Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллага, соёлын байгууллагуудын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг орон нутгаас олгож байгаа ч 6 байгууллагын 17.5 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

- *Баянхонгор аймгийн СТСХ нь аймгийн Засаг даргын харьяаны байгууллага, сумдын Засаг даргын тайлан дахь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу жилийн эцсийн тайланд тайлагнасан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг нэгтгэж дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.*

Иймд харьяа байгууллага, сумдын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

- ✓ ҮАГ-ын 2024 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 06/08 дугаар албан бичгээр ирүүлсэн аудитад анхаарах асуудлын хүрээнд аймгийн болон сумдын ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ-ын удирдлагууд газар, хэлтсийн дарга нар гадаад орнуудад сургалт болон аялалын зорилгоор томилолт олгосон асуудлыг шалгав.

Аудитын илрүүлэлт:

- *Баянхонгор аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын хэмнэлтээс аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/614 дүгээр захирамжаар 10.8 сая төгрөгийг АДЗТГ-ын гадаад томилолтын зардалд зарцуулсан зөрчил илэрсэнд аудитаар албан шаардлага хүргүүлэв.*

- Баянхонгор аймгийн Засаг даргын А/567 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нар Япон улсад туршлага судлахад 22.9 сая, А/689 дугаар захирамжаар сумдын Засаг дарга нар Турк улсад туршлага судлахад 52.5 сая төгрөг нийт 75.4 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас зарцуулсан зөрчилд аймгийн ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн болно.

БҮЛЭГ 4. ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Монгол УИХ-аас төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр баталж мөрдсөн Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 6,7 дугаар саруудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хослуулан шалгахад 11 байгууллагад 18.3 сая төгрөгийн 14 зөрчил илэрлээ. Үүнээс 12.7 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, Бууцагаан сумын ЗДТГ-т 4.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгч, Заг сумын ЗДТГ-т 1.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн ба тус хуулийг мөрдөж ажиллаагүй дараах зөрчлүүд аудитаар илэрсэн байна. Үүнд:

6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/280 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталж бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.

Дээрх тушаалд үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжилтийг хангах тухай” А/103 дугаар захирамжаар “Орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээд тээврийн хэрэгслийг ашиглаж, эзэмших журам”, “Албан тушаалын, албан ажлын суудлын автомашины тоо, төрөл, автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг баталж журмаар зөвшөөрөгдөөгүй нийт 78 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосон байна.

Тус захирамжийн дагуу төсөвт байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан 56 автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт татан төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 30 тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, төсөвт 284.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд нэг автомашин зарагдаагүй, 4 автомашин шийдвэр гараагүй, 6 автомашиныг акталж, 15 автомашиныг автомашин дутагдалтай төсөвт байгууллагуудад балансаас баланст шилжүүлсэн бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2, 6.5 дах заалтад 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан 14 тээврийн хэрэгслийг тухайн байгууллагад нь үлдээхээр шийдвэрлэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа 42 байгууллагын 142 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 24 байгууллагын 75 тээврийн хэрэгсэл буюу 52.8 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд Аймгийн Засаг даргын харьяа 24

байгууллагын 75 тээврийн хэрэгслийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

- Өмнөх аудитаар Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын “Албан тушаалын, албан ажлын суудлын автомашины тоо, төрөл, автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг баталж журмаар зөвшөөрөгдөөгүй нийт 78 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байхад 5 сумын 209.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 8 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн тул Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын дагуу татан төвлөрүүлэх, тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэлгүй, 5 сумын 8 суудлын автомашиныг татан төвлөрүүлж дуудлага худалдаанд оруулаагүйгээс аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан доод үнийн дүнгээр тооцоход 74.5 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

8 дугаар зүйл. Дүрэмт хувцас

Эрдэнэцогт сумын ИТХ-ын санхүүгийн тайлангийн аудитаар хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/11 дугаар тушаалаар сумын ИТХ-ын төлөөлөгчид Баянхонгор аймагт зохион байгуулагдсан спортын өдөрлөг арга хэмжээнд оролцоход зориулж 0.2 сая төгрөгийн биеийн тамирын цамц худалдаж авсан байна.

12 дугаар зүйл. Бусад хангамж

Бусад хангамжийн зардал болох гар утасны зардал, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсвэл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, хэвлэлийн захиалгын төлбөр зэрэг зардлуудыг төсвөөс төлөхөөр төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэсэн заалтыг хэрэгжүүлэлгүй, тайлант онд Баян-Овоо сумын ЗДТГ 0.4 сая төгрөгийн гар утасны нэгжийн үнийг 29 албан хаагчид олгосон зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг Жинст, Богд, Баянцагаан сумын ЗДТГ-ууд зөрчиж, ойн баяр, шашин урлагийн цэнгүүн, дуучны цомгийн зардалд 4.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсныг нөхөн төлүүлэх төлбөрийн актыг эдгээр байгууллагуудад хүргүүлсэн байна.

13 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд 12,786.9 сая төгрөгийн 70 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

- ✓ Тайлант онд 10,752.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 10,478.0 сая төгрөгийн 43 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан байна.

Хүснэгт 13.Худалдан авах ажиллагааны тайлан (сая.төг)

д/д	Санхүүжилтын үсвэрийн нэр	эх	Төсөл арга хэмжээний тоо	ХАА-д журам мөрдсөн			төсөвт өртөг	тухайн онд санхүүжих дүн	гэрээ байгуулсан	
				НТШ	ХА	ЗӨ			тоо	мөнгөн дүн
1	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр		26	21	5		8,792.6	4,274.8	26	8,605.5
2	орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар		8	2	6		572.6	474.6	7	525.6

3	орон нутгийн замын сангийн хөрөнгөөр	7	4	3		1,137.0	1,137.0	7	1,106.2
4	Байгаль орчныг хамгаалах сангийн хөрөнгөөр	3	1	1	1	250.0	160.0	3	240.7
	Нийт дүн	44	28	15	1	10,752.2	6,046.4	43	10,478.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ОНӨГ-ын жилийн эцсийн тайлан

Дээрх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний тендер зохион байгуулалтын үйл ажиллагаа 100%-ийн биелэлттэй гарсан байна.

Орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-т заасан хориглох хөрөнгө оруулалтыг тусгаагүй байна.

15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ

Санхүүгийн тайлангийн аудитаар 6 байгууллага баяр тэмдэглэх, чуулга уулзалтыг зохион байгуулах, хүндэтгэл үзүүлэх зэрэг арга хэмжээнд 10.9 сая төгрөгийг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн зөрчилд 4.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 5.3 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Хүснэгт 14. Хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зөрчлийн нэгтгэл (сая.төг)

Хуулийн заалт	Зөрчил гаргасан байгууллагын тоо	Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
15 дугаар зүйлийн 15.1.3.	3	1	4.0	1	1.6	2	0.9	4	6.5
15 дугаар зүйлийн 15.1.5.	1					1	0.2	1	0.2
15 дугаар зүйлийн 15.2.3.	2					3	4.2	3	4.2
Дүн	6	1	4.0	1	1.6	6	5.3	8	10.9

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТӨЛБӨРИЙН АКТЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,721.8 сая төгрөгийн алдаа зөрчил илүүлснээс 13.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 523.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 1,184.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 8 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 7/1651 дугаар албан бичгээр гаргаж ирүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, “Айти Юнипикэшн” ХХК-ийн хооронд байгуулсан “Виртуал студийг менежментээр хувьчлах гэрээ”-ний дагуу зээлийн эргэн төлөлтийг хугацаанд төлөөгүй зөрчил өмнөх аудитаар илэрч төлбөрийн акт тогтоосон байхад барагдуулаагүй тул хууль хяналтын байгууллагад илжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 2022 оны аудитаар өгсөн зөвлөмжийг гарсан алдаа зөрчилтэй харьцуулан үнэлэхэд зөвлөмжийн биелэлт 71.3 хувьтай үнэлэгдэж байна.

Хүснэгт 15. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

№	Аудитаар өгсөн албан шаардлага	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
Аймгийн ИТХ-д толилуулах нь:			
1	1. "Баянхонгор үйлдвэржил хөгжлийн корпорац" ХХК-ийн алдагдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж 2022 оны эцэст 332.3 сая буюу хуримтлагдсан алдагдал 1,032.3 сая төгрөг хүрсэн тул үйл ажиллагааны үр дүнг нь нэн даруй хэлэлцэж, цаашид ямар хэлбэрээр орон нутгийн хөгжлийг дэмжих талаар шийдвэр гаргах шаардлагатай байна.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Баянхонгор үйлдвэржил хөгжлийн корпорац" ХХК нь 2022 оны жилийн эцэст 332.3 сая буюу хуримтлагдсан алдагдал 1.032.3 сая төгрөгт хүрсэн. Тус байгууллагын үндсэн хөрөнгө болох барилга байгууламжийн анхны өртөг 4,083.2 сая төгрөгийг Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, ААНОАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг үндэслэн элэгдлийн жилийг тооцож бүртгэсэн бөгөөд одоогоор хуримтлагдсан элэгдэл 1,037.3 сая төгрөг ба дээрх алдагдал нь үндсэн үйл ажиллагааны алдагдал биш хуримтлагдсан элэгдлийн зардал болно.
		Аудитаар тооцсон биелэлт	"Баянхонгор үйлдвэржил хөгжлийн корпорац" ХХК нь үйл ажиллагааны үр дүнг аймгийн ИТХ-аар хэлэлцээгүй байна. Биелэлт 0%
2	2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17.1.1 дэх заалттай уялдуулан "Ингэн эрдэнэ", "Баян өсөх агро" ОНӨААТҮГ- уудын үйл ажиллагааг хувьд шилжүүлэх замаар төсвийн хөрөнгийг үр ашгийг дээшлүүлэх асуудлыг анхаарч үзнэ үү.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	"Ингэн Эрдэнэ", "Баян өсөх агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тайланг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	"Ингэн Эрдэнэ", "Баян өсөх агро" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тайланг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр ИТХ-аар хэлэлцсэн байна Биелэлт 100%
Баянхонгор аймгийн Засаг даргад			
1	Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг аймгийн төсөвт тусгайлан баталж хэрэгжүүлэх.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Монгол улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд Монгол Улсын Сангийн яамтай байгуулсан гэрээний дагуу 2023 оны эргэн төлөгдөх зээлийг аймгийн Орон нутгийн төсөвт батлуулж, зээл төлөлтийн хуваарийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 7/737 албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. 2023 онд орон нутгийн төсвөөс 967.1 сая, "Баянхонгор Эрчим хүч" ЦТ ХХК-аас 45.8 сая, Чандмань Баянхонгор ХК-аас 41.6 сая, нийт 1.054.5 сая төгрөгийн үндсэн зээл болон хүүгийн төлбөр төлсөн.
		Аудитаар тооцсон биелэлт	Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг аймгийн төсөвт 750.7 сая төгрөгийн эх үүсвэрийг баталж 663.1 сая төгрөгийг төлсөн байна. Биелэлт 100%
2	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 2023 онд орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж зарцуулах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аж ахуй нэгжийн орлогын албан татвараар өмнөх оны урьдчилж орсон орлого 448.3 сая төгрөгийг гүйцэтгэлээр авч 2023 онд 665 сая төгрөг төлөвлөснөөс жилийн эцсийн гүйцэтгэлээр 677.4 сая төгрөг орж 12.4 сая төгрөгийн орлого давж орсон байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайланд аж ахуй нэгжийн орлогын албан татварын 665.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 229.1 сая, өмнөх оны урьдчилж орсон орлого 448.3 сая нийт 677.4 сая төгрөг биелэсэн байна. Биелэлт 100%

3	“Хүмүүнлэгийн ордон”-ы үйл ажиллагааг сайжруулж менежментийн хувьчлалаар хувьчлах арга замыг боловсруулж цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилгуудын ашиглах тогтмол зардлыг төсвийн жилдээ тооцоогүйгээс орон нутгийн төсөвт хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсоох.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай тогтоолоор "Хүмүүнлэгийн ордон"-ний үйл ажиллагааны зардалд 120.0 сая төгрөг баталж, 2023 оны гүйцэтгэлээр 120.0 сая төгрөг зарцуулсан.
		Аудитаар тооцсон биелэлт	Баянхонгор аймгийн Засаг дарга 2023 оны 3, 7 дугаар саруудад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, 07 дугар сард 11 дүгээр сард УИХ-ын даргад албан бичиг хүргүүлж, “Хүмүүнлэгийн ордон”-ы үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх хүсэлтийг хүргүүлсэн боловч хариу албан бичиг ирээгүй байна. Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай тогтоолоор "Хүмүүнлэгийн ордон"-ний үйл ажиллагааны зардалд 120.0 сая төгрөг баталсныг хэтрүүлэн зарцуулаагүй байна. Биелэлт 100%
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад			
1	Сумын ИТХ-аар тодотгон баталсан тогтоолыг өөрчлөлтийг тухай бүр санхүүгийн төлөвлөлтийг программд оруулан зөв нэгтгэж байх.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аймгийн 2023 оны төсөв баталсан, тодотгосон тогтоол, Сумдын 2023 оны төсөв баталсан, тодотгосон тогтоолуудыг нэгтгэн зардлын эх үүсвэр, зардал, түүний тэнцэл үнэн зөв эсэх, тусгайлан заасан хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж алдааг тухай бүр залруулан төсвийн төлөвлөлтийн Фискал программд 2023 оны 1 дүгээр сард, тодотгосон тогтоолуудыг тухай бүр байгууллага, сан тус бүрээр орлого, зарлагын хуваарийг шивсэн.
		Аудитаар тооцсон биелэлт	Аудитаар сумын ИТХ-аар баталсан тогтоол, төсвийн тодотголыг санхүүгийн төлөвлөлтийн програмаас татаж авсан файлтай тулгахад зөрүү илэрээгүй Биелэлт 100%
2	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч тайлант онд 251.3 сая төгрөгийн зураг төсвийн авлага төлүүлж ажилласан.
		Аудитаар тооцсон биелэлт	Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн эзэн холбогдогч нь тодорхой биш авлагыг эрх бүхийн байгууллагаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулаагүй байгаа тул 2024 оны 4-5 дугаар сард хийгдэж байгаа “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар тодруулан шалгахгаар Биелэлт 0%
Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт			
1	Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлдэгчийн зээлийн гэрээний үүргээ биелүүлж байгаад тавих хяналтыг сайжруулж, эргэн төлөлтийн хуваарийг үндэслэн эх үүсвэрийг бодитой төлөвлөж, зээлийн эргэн төлөлтөөс бий	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	2023 оны төсөвт сумдууд орон нутгийн төсөвт хоршоо хөгжүүлэх санд зээлийн эргэн төлөлтөөр орох орлогыг 1,298.9 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс жилийн эцсийн гүйцэтгэлээр 1,181.0 сая төгрөг орсон, Үүнээс тайлант онд 1.014.9 сая төгрөгийг зээлд олгосон.

	болсон эх үүсвэрийг дараагийн зээлд олгож төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх.	Аудитаар тооцсон биелэлт	Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөх орлогоос 1,298.9 сая төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр 1,181.0 сая төгрөгийг төвлөрүүлж 90.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба тайлант хугацаанд 1.014.9 сая төгрөгийн зээл олгосон байна. Биелэлт 90.9
2	Малын тоо толгойн албан татварыг жилийн эцсийн мал тооллогын статистик мэдээ, Татварын хэлтсээс үүсгэсэн нэхэмжлэх, өмнөх оны орлогын гүйцэтгэл зэрэгтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх, хяналт тавьж ажиллах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Малын тоо толгойн албан татварыг жилийн эцсийн мал тооллогын статистик мэдээ, татварын газраас үүсгэсэн нэхэмжлэх, өмнөх оны орлогын гүйцэтгэл зэрэгтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх чиглэл өгсөн.Сумдын ИТХ-аар 2023 онд малын тоо толгойн албан татварт 1,566.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулахаар баталсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 1,299.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 83 хувийн биелэлттэй байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Тайлант онд малын тоо толгойн албан татварыг 1,566.1 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,292.9 сая төгрөг буюу 82.5 хувийн биелэлттэй байна. Биелэлт 100%
3	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст сумдын хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн шийдвэр, гэрээ, ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээ, бусад санхүүгийн үр дагавар бүхий гэрээнүүдийг байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах, тайлагнах төлөвлөгөөг гарган, хэлтсийн даргаар баталгаажуулан ажилласан.
		Аудитаар тооцсон биелэлт	Тайлант онд төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрт 119 мэдээллийг байршуулсан бөгөөд үүнээс 33 мэдээллийг хугацаа хоцроосон ба Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа "Мэлтэс Оргих" ХХК, "Монголболгар гео" ХХК, аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-г аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байгаа тул Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар зөвлөмжийг хүргүүлсэн. Биелэлт 72.3%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			71.3%

Эх сурвалж: Байгууллагын ирүүлсэн албан бичиг, Санхүүгийн тайлан FAS системд оруулсан биелэлт

БҮЛЭГ 6. БАЯНХОНГОР АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 3,169.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 6 санал, суурь зарлагыг 1,133.3 сая төгрөгөөр бууруулах 9 санал, төсвийн үр ашгийг 5,753.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 9 санал, нийт 10,056.0 сая төгрөгийн 24 саналыг хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд өгсөн саналыг хүлээн авсан эсэхийг аудитаар эргэн шалгахад дараахь саналуудыг хүлээн аваагүй байгаа, саналыг аваагүй тайлбарыг холбогдох мэргэжилтнүүд дараах байдлаар ирүүлсэн болно.

- Авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 2022 онд 900.0 сая төгрөгөөр нэхэмжлэл үүсгэсэн боловч автомашинаа бүртгүүлсэн мөртлөө замын хөдөлгөөнд оролцдоггүй, тээврийн хэрэгслээ хасалт хийлгээгүйгээс татвар төлөгчийн тоо их

байдаг гэсэн үндэслэлээр авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 290.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүлээж аваагүй;

- Хог хаягдлын хураамжийн орлогыг Сангийн яамнаас 700.0 сая төгрөгөөр хянасан, хураамжийг тооцохдоо Статистикийн дүн мэдээ, сумын ИТХ-аар баталсан тогтоолыг баримталж тооцсон гэсэн үндэслэлээр Хог хаягдлын хураамжийн орлогыг 80.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүлээж аваагүй;
- Уул уурхайн компаниудын ус ашигласан төлбөр нь тоолуурт шилжсэнтэй холбоотой усны төлбөр өмнөх онуудтай харьцуулахад ногдуулалт бага гардаг болсон тул ус, рашаан ашигласны төлбөрийг 69.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүлээж аваагүй;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй 619.8 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээгээр бууруулах саналыг тухайн сумын төлөөлөгчөөр дамжуулан намын бүлгийн хурлаар хэлэлцэн оруулж дэмжигдсэн тул хасаагүй;
- Аймгийн ИТХ-ын дэргэдэх зөвлөл, хороо, комисс үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа гэсэн үндэслэлээр аймгийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдсан зөвлөл хороо, комиссын гишүүдийн урамшууллыг 30.0 сая төгрөгөөр бууруулах саналыг хүлээн аваагүй;
- Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын спорт заалнуудыг менежментийн хувьчлалд оруулснаар төсвөөс гарах урсгал зардлыг 359.0 сая төгрөгийн үр ашгийг сайжруулах саналыг аймгийн Засаг даргын дэргэдэх Удирдлагын зөвлөл дэмжээгүй;
- Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 3,251.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээний 1,510.4 сая төгрөгийг 2023 онд, үлдэх 1,741.2 сая төгрөгийн санхүүжилтийг 2024 онд олгохоор төлөвлөснийг 2023 онд санхүүжилтийг бүрэн олгож ажлыг дуусган, төсвийн үр ашгийг дээшлүүлэх саналыг намын бүлгээр хэлэлцэж он дамжин хэрэгжүүлэх саналыг гаргасны улмаас хүлээн аваагүй;
- “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын удирдлагуудтай ярилцлага хийхэд “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд зуны улиралд 10 гэрээт ажилтан ажиллуулах, Төрийн аудитын газраас санал оруулсан 5 орон тоог зайлшгүй шаардлагатай гэсэн үндэслэлээр тус байгууллагын орон тоог бууруулах саналыг хүлээн аваагүй байна.

Аудитаар нийт 2,455.3 сая төгрөгийн 17 алдаа, зөрчил илэрч, санхүүгийн тайланд 127.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 4.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1,724.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага өгч, 598.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 7 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Баянхонгор аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч зарим аж ахуйн нэгжүүд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс хандивын орлогоос 1,418.1 сая төгрөгийн эх үүсвэр дутагдсан, өмнөх онуудад олгосон Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-аас хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийн авлага 672.4 сая төгрөг байгаа зэргээс шалтгаалж 7 төсөл арга хэмжээнд 521.5 сая төгрөгийн өглөг үүссэн байна.
2. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны ТШЗ, ТТЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг нэгтгэж дүгнээгүй, дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.
3. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийг төсвийн тухай хуулийн 22.2.4 дэх хэсэг, 24.5, 24.6 дахь заалтын дагуу батлуулж ажилласан байна.
4. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолоор сумын Соёлын төвд тоног төхөөрөмж бэлтгэх 4 төсөл арга хэмжээ, Баянхонгор сумын хогийн цэг булшлахад 3 төсөл арга хэмжээ, "Тэрбум мод", өвлийн хүлэмж, ногоон байгууламжийн усалгаатай холбоотой 4 арга хэмжээ, нийт 11 төсөл арга хэмжээ тус бүрд 20.0 сая төгрөгийг баталсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.
5. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчин аймгийн ИТХ-аар баталсан төсөл арга хэмжээний зардлыг илүү олгосон байна.
6. Төсөвт байгууллагуудад ашиглаж байгаа тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй, төрийн байгууллагад хэрэглэж байгаа тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгах өнгө бүхий улсын дугаарыг аваагүй, төсвийг зориулалт бусаар ашигласан зэргээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй байна.
7. Өлзийт, Хүрээмарал сумдын ОНХС-ийн бүртгэлийг үнэн, зөв тайлагнаагүй байна.
8. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд болон аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна.
9. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 793.3 сая төгрөгийг олгохоор баталсан байхад гүйцэтгэлээр 795.6 сая төгрөгийг олгож, баталсан төсвөөс 2.3 сая төгрөгийг илүү олгосон байна.
10. Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд олгохоор төлөвлөсөн 1,483.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 9 сум олгоогүй байна.
11. Сангийн яамны Э-тайлан дахь орлогын гүйцэтгэлийн тайлангийн орлого 67,842.7 сая, гүйцэтгэл 67,426.2 сая төгрөг байгаа нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын гүйцэтгэл 69,606.2 сая буюу 2,180.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хандивын орлогын гүйцэтгэлийг гадаадын эх үүсвэр дансаар төлөвлөгөөг оруулсантай холбоотой байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Баянхонгор аймгийн ИТХ-д толилуулах нь

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэт жижиглэн батлахгүй байх асуудлыг анхаарч үзнэ үү.

Хоёр. Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танаа

- Аймгийн Засаг даргын харьяа байгууллага, сумдын Засаг дарга нарын Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлагнасан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг аймгийн хэмжээнд нэгтгэн, дүн шинжилгээ хийж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх
- Аймгийн ИТХ-аар баталсан төсөл арга хэмжээний зардлыг Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг дагуу олгож байх
- Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэж, аймаг, сумдын ИТХ-д тайлагнаж байх
- Аймаг, сумдын ОНХС-ийн орлого, зардлын бүртгэлийг мөрдөж буй НБББББ-т тодорхой тусган, бүртгэл хөтөлөлтөд тавих хяналтыг сайжруулах
- ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, зураг төсвийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, дутуу олгогдсон 521.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг 2024 онд ОНХС-аар хэрэгжих ТАХ-ын жагсаалтад оруулах
- Хандивын орлогын төлөвлөгөөг Сангийн яамны Э-тайланд үнэн зөв оруулах

Хоёр. Баянхонгор аймгийн Татварын газрын дарга С.Рэнцэндагва танаа

- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод тавих хяналтыг сайжруулж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй хамтран ажиллах уялдаа, холбоог сайжруулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2024 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХБТХОХ, аймгийн Татварын газрын хамт олонд талархал илэрхийлье.

оОо